

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-4

1. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	3-4
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирээл зохих 23 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 52.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 12 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Жаргалсайхан, Ж.Золжаргал;
Чөлөөтэй: Б.Пунсалмаа, Б.Тулга;
Тасалсан: Д.Батбаяр, Ц.Даваасүрэн, С.Лүндэг, П.Мөнхтулга, Г.Очирбат, Д.Пүрэвдаваа.

Нэг. “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Ганбаатар: “Ажлын хэсгийн удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 69.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 23 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 56.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим, 12 цаг 12 минут

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Эрхэм хүндэт гишүүдийн амар амгаланг айлтгая. Шинэ оны мэнд хүргэе. Та бүхэндээ 2025 оны ажлын өндөр амжилт хүсье.

Өнөөдрийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаан эхэлснийг мэдэгдэж байна.

Та бүхэнд ирцийг танилцуулъя. Сайнхүүгийн Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна. Бадамсүрэн гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна. Сонгойбайн Замира гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн ирсэн байна. Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн байна. Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна. Хажикберийн Жангабыл гишүүн ирсэн байна. Лувсанбаямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн ирсэн байна. Ингээд ирц 56.5 хувьтайгаар өнөөдрийн хуралдааныг эхлүүлж байна. Ингээд Байнгын хорооны гишүүдийн ирц 56.5 болсон учраас 2025 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал. “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, үйлдвэрлэл технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсэг гэсэн ийм Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тарааж, танилцуулсан байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудал дээр Бадамсүрэн гишүүн нэг санал оруулж ирсэн. Энийг бол дараагийн хуралдаанаар хэлэлцээд, шууд мэдээллийг нь сонсоод, ажлын хэсгийг нь байгуулахаар бид тогтож байгаагаа энд хэлье. Тэр нь бол жижиг, дунд үйлдвэрлэлийн тухай санал сая бас ярьсан.

Ингээд өөр хэлэлцэх асуудал байхгүй байгаа учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаас гаргасан саналын дагуу Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт болон үйлдвэр технологийг паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажлын явц, цаашид

шийдвэрлэх асуудлын талаарх мэдээллийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцсэнтэй холбогдуулан хууль тогтоомжуудын хэрэгжилт, үйлдвэр технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийг Байнгын хорооны 2024 оны 08 дугаар тогтоолоор байгуулсан.

Өнөөдрийн хуралдаанаар дээрх ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Ингээд та бүхэнд тараасан байгаа учраас тогтоолын төсөлтэй холбогдуулан саналтай гишүүд нэрээ өгнө үү. Тогтоолын төсөл дээр санал хэлэх гишүүн гараагүй учраас тогтоолын төслийн талаар саналтай гишүүн байхгүй байна.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэгээрээ бол санал л хэлэх юм байна шүү.

Ингээд санал хураалтыг явуулъя. 61.5 хувиар тогтоолын төсөл батлагдлаа. Замира гишүүнийг тогтоолын төслийг дэмжсэнээр протоколд тусгая.

Ингээд санал хураалтын дүнг танилцуулъя. 61.5 хувиар гишүүд дэмжиж, тогтоолын төсөл дэмжигдлээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан туд өнөөдрийн хуралдааныг өндөрлөж байна.

12.17 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ